

Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны Эрүүл мэндийн газрын даргын 1970.07.01-ний өдрийн 126 тоот тушаалаар Сүхбаатар дүүргийн 2 дугаар эмнэлгийг 50 ортой хүүхдийн тасаг, тусгай тасаг, аж ахуйн тасгуудтайгаа үүсгэн байгуулагдсан.

1991 оноос Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг нь Хүүхдийн 2-р эмнэлэг, Сүхбаатар Эрүүл Мэндийн Зөвлөх төв гэсэн хоёр тусдаа байгууллага болон ажиллаж, 1997 оноос Эрүүл мэндийн зөвлөх төв, Хүүхдийн 2-р эмнэлгийг нэгтгэн "Сүхбаатар" Эрүүл мэндийн Нэгдэл болгон зохион байгуулсан.

2004 онд "Сүхбаатар" дүүргийн Нэгдсэн эмнэлэг бие даан удирдлагын багаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго : Удирдлагын үйл ажиллагааны шинэчлэлийн үр дүнд хүн амд үзүүлж, байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг таатай орчинд, чанартай, жигд, хүртээмжтэй, шуурхай үзүүлэх тогтолцоог бий болгох.

Тус эмнэлэг нь Сүхбаатар дүүргийн нийт : 124728 хүн амд, мөн Чингэлтэй дүүргийн 0-16 насны 37012 хүүхдэд, нийт 161740 хүн амд дүүргийн нэгдсэн эмнэлгийн хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээг үзүүлдэг. Эмнэлэг нь 185 ортой

- Хүүхдийн 90 ортой /85 ор тасагтай, 5 ор эрчимт эмчилгээ/

- Насанд хүрэгчдийн 95 ор / 90 ор тасагт, 5 ор эрчимт эмчилгээнд / тус бүр ажиллаж байна.

Нэгж бүтэц:

Захиргаа аж ахуйн тасаг / хүний нөөц гадаад харилцааны алба, санхүү аж ахуйн тасаг, эмийн сан, эмчилгээний хоолны тасаг, дүн бүртгэл, мэдээлэл, эмчилгээ, чанарын хяналтын комисс, угаалга/

Насанд хүрэгчдийн тасаг/ Дотор мэдрэл, уламжлалт эмчилгээ, эрчимт эмчилгээ,

Хүүхдийн тасаг /Сургуулийн өмнөх насны хүүхэд, сургуулийн насны хүүхэд, эрчимт эмчилгээ/

Тусламж үйлчилгээний тасаг /хүлээн авах, пара клиник, эмгэг анатоми, ариутгал, декаметр/ гэсэн тасаг хэсэгтэйгээр ажиллаж байна.

Боловсон хүчин 154 эмч, эмнэлгийн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс: 27 их эмч 42 сувилагч, 12 дунд мэргэжилтэн, 40 асрагч 2шил угаагч, 24 албан хаагч, ИТА, слесарь, мужаан, зэрэг бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт эмч нарын 18% нь тэргүүлэх зэрэгтэй, 18% ахлах зэрэгтэй байна.

Нийт сувилагч нарын 10% ахлах зэрэгтэй байна.

Үйл ажиллагаа:

2004 оны 02 сараас эхлэн Удирдлагын багаар ажиллуулж ирсэн. Энэ хугацаанд байгууллага ард иргэддээ чанартай, хүртээмжтэй, тусламж үйлчилгээг, явуулан ажиллаж байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн тоо жил бүр өсч, эмнэлгийн нас бар алт 5 жил дараалан буурсан.